

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/48-ШТА-ГА

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Т.Хүрэлбаатар
Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn
Аудитор Б.Одбилэг
Утас: 70273204 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn
Аудитор Б.Адъяасүрэн
Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

<u>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.</u>	3
<u>БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.</u>	4
А.1 Хөрөнгө шийдвэрлэх тухай зарим тогтоол, шийдвэрүүд нь хууль, журамд нийцээгүй байна.	4
А.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтийг үр дүн муутай зохион байгуулсан байна.	4
<u>БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.</u>	5
Б.1. Хөрөнгө шийдвэрлэх тогтоолын хэрэгжилт нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.	5
Б.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын дагуу хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгасан байна.	7
<u>БҮЛЭГ В. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаас баталсан 2020-2024 оны “Хөрөнгө шийдвэрлэх тухай” тогтоолын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.</u>	10
В.1. Худалдан борлуулсан хөрөнгийн үнэ төсөвт дутуу буюу 44,7 хувьтай төвлөрсөн байна.	10
В.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо болон Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газрууд хяналт тавьж ажиллаагүй байна.	13
<u>ДҮГНЭЛТ:</u>	13
<u>ЗӨВЛӨМЖ:</u>	14
<u>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:</u>	15
<u>Хүснэгтийн товьёг</u>	
Хүснэгт 1 Дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэрийн хэрэгжилт	6
Хүснэгт 2 Балансаас баланст шилжүүлэх шийдвэрийн хэрэгжилт	7
Хүснэгт 3 Акталж устгах шийдвэрийн хэрэгжилт	7
Хүснэгт 4 Нийт худалдан борлуулахаар шийдвэрлэсэн хөрөнгийг дансны ангиллаар харуулбал	10
Хүснэгт 5 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн барилга байгууламжийг аудит хамрах хугацаагаар харуулбал:	11
Хүснэгт 6 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн тээврийн хэрэгслийн аудит хамрах хугацаагаар харуулбал:	11
Хүснэгт 7 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн тээврийн хэрэгслийн аудит хамрах хугацаагаар харуулбал:	12
Хүснэгт 8 Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан тээврийн хэрэгслийн орлогыг төвлөрүүлсэн байдал хэрэгжилтийг аудит хамрах хугацаагаар харуулбал	12

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТАГ	Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн Өмчийн газар

ᠠᠳᠪᠣᠤᠪ
ᠠᠳᠪᠣᠤᠰ
ᠲᠠᠭ
ᠢᠲᠬ
ᠵᠳᠲᠭ
ᠣᠨᠥᠭ

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын
хязгаарлалт**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Хүндрэл бэрхшээл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны А/107 дугаар тушаал, Төв аймаг дахь ТАГ гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн хийлээ.

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолуудын хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг Аймгийн Засаг дарга, ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго оршино.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтийг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна уу?
- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна уу?
- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй байна уу?

Аудитад Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолууд, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, мөн төсөвт байгууллагын 2020-2024 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлыг аудитад хамруулахгүй.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000
- Монгол Улсын төрийн аудитын стандарт
- MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”
- MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”
- MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”
- MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”
- “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал удирдаж, аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хүрэлбаатар, аудитор Б.Одбилэг, Б.Адъяасүрэн нар гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 7 дугаар сарын 21-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2025 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт хүргүүллээ.

Байхгүй

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

А.1 Хөрөнгө шийдвэрлэх тухай зарим тогтоол, шийдвэрүүд нь хууль, журамд нийцээгүй байна.

Аудитын хамрах хугацаанд хөрөнгө шийдвэрлэх тухай нийт 25 тогтоол гаргасан байна. Үүнд:

- 2020-2021 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаас 23 хавсралт бүхий 11 тогтоол,
- 2022-2024 онд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 35 хавсралт бүхий 14 тогтоол тус тус батлагджээ.

Уг тогтоолуудаар нийт 13,781.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 5235 ширхэг үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байна.

Уг тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны VI дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам" зэргийг мөрдлөг болгосон байна. Мөн дээрх хугацаанд гаргасан зарим тогтоолууд нь хууль, журамд нийцэхгүй байна. Тухайлбал:



Акталж данснаас хасахаар шийдвэрлэсэн 4,388.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3610 ширхэг үндсэн хөрөнгөнд 1,426.7 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 1202 ширхэг үндсэн хөрөнгө байна. Уг хөрөнгөтэй холбоотой ашиглалтын хугацаа дуусаагүй, тодорхой этгээдийн буруутай үйл ажиллагааны улмаас үрэгдэж алга болсон, техникийн осолд өртөж цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, ашиглалтын явцад эвдэрч гэмтсэн болохыг тодорхойлсон болон учирсан хохирлын хэмжээг тогтоож, барагдуулах талаар гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэр, төлбөр төлөгдсөн баримт байхгүй байна. Өөрөөр хэлбэл акталж, данснаас хасах эд хөрөнгийн шалгуурыг хангаагүй байхад данснаас хасах шийдвэрийг аймгийн ИТХ-аас гаргасан байна. Үлдэх өртөгтэйгөөр акталж данснаас хассан хөрөнгөнд дахин үнэлсэн хөрөнгүүд мөн багтаж байна.

А.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтийг үр дүн муутай зохион байгуулсан байна.

Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтийг Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны VI дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн өмчийн харилцааг зохицуулах журам"-ын дагуу зохион байгуулан ажилласан байна.

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас 2020-2024 онд хөрөнгө шийдвэрлэх тухай нийт 58 хавсралт бүхий 25 тогтоол гаргаснаас 4,252.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 442 ширхэг үндсэн хөрөнгийг 2,502.7 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар, 4,671.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 1136 ширхэг үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэхээр, 345.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий 34 ширхэг үндсэн хөрөнгийг сэлбэгээр 33.5 сая төгрөгөөр худалдан борлуулахаар, 46.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3 ширхэг үндсэн хөрөнгийг сэлбэгээр ашиглахаар, 4,388.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 3610 ширхэг үндсэн хөрөнгийг акталж устгахаар буюу нийт



13,704.7 сая төгрөгийн балансын үнэ бүхий 5225 ширхэг үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байна.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газраас дээрх тогтоолуудыг хэрэгжүүлэхээр 2020-2024 онд 15 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулж 2,536.2 сая төгрөгөөр худалдан борлуулах доод үнэ бүхий 476 ширхэг үндсэн хөрөнгөөс 858.1 сая төгрөгийн 144 ширхэг үндсэн хөрөнгийг 878.2 сая төгрөгөөр худалдан борлуулсан байна.

Нийт 2,536.2 сая төгрөгөөр худалдан борлуулахаар шийдвэр гарсан 476 ширхэг хөрөнгөөс 144 ширхэг хөрөнгийг дуудлага худалдаагаар 878.2 сая төгрөгөөр худалдан борлуулсан буюу хэрэгжилт 34,6 хувьтай байна.

Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан 878.2 сая төгрөгийн орлогоос төсөвт 393.2 сая төгрөг төвлөрсөн буюу хэрэгжилтийн хувь 44,7 хувьтай байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит бус 7 дугаар хуралдааны 7 дугаар тогтоолоор “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын хуучин дулааны станцын 188.4 сая төгрөгийн өртөг бүхий 140 ширхэг тоног төхөөрөмжийг, 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 19 дүгээр хуралдааны 7 дугаар тогтоолоор “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын хуучин дулааны станцын барилга дээр 411.9 сая төгрөгийн үнэлгээтэй газрыг нэмж, 188.4 сая төгрөгийн өртөг бүхий 140 ширхэг тоног төхөөрөмжийг тус тус дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэж хэрэгжээгүйгээс хэрэгжилтийн хувь багасах үндсэн шалтгаан болсон байна.



БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ НЬ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Хөрөнгө шийдвэрлэх тогтоолын хэрэгжилт нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Аймгийн ИТХ нь 2020-2024 онуудад нийт 25 тогтоолоор 13,704.7 сая төгрөгийн 5225 барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах, балансаас баланст шилжүүлэх, сэлбэгээр худалдах болон ашиглах, акталж устгах шийдвэр гарчээ.

Дуудлага худалдаагаар нийт 4,252.6 сая төгрөгийн үнэтэй, 1,468.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 442 ширхэг хөрөнгийг 2,502.8 сая төгрөгөөр худалдан борлуулах шийдвэр гаргасан байна. Энэхүү шийдвэрийн хүрээнд 27,0 хувийг 835.1 сая төгрөгөөр худалдсан бөгөөд уг худалдсан хөрөнгийн дүнгийн 45,0 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

*Хүснэгт 1 Дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэрийн хэрэгжилт /дансны ангиллаар/
/Сая төгрөгөөр/*

№	Дансны нэр	Худалдан борлуулахаар шийдвэрлэсэн		Худалдан борлуулсан				Худалдан борлуулаагүй хөрөнгө		Хэрэгжилт
		Тоо ширхэг	Худалдах үнэ	Тоо ширхэг	Худалдсан үнэ	Төсөвт төвлөрүүлсэн дүн	Төсөвт төвлөрөөгүй дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн	
1	Барилга байгууламж	25	1,731.1	15	146.9	97.1	49.8	10	1,578.8	60.0%
2	Тээврийн хэрэгсэл	137	394.8	103	688.2	277.3	411.0	34	95.6	74.1%
3	Тоног төхөөрөмж	280	376.8	-	-	-	-	280	-	
	Нийт дүн	442	2,502.8	118	835.1	374.4	460.7	324	1,674.4	26.6%

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Нийт 4,671.3 сая төгрөгийн үнэлгээ бүхий 1,136 хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх шийдвэр гаргасан бөгөөд үүнээс 2 нэр төрлийн, нийт 20.5 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг 2 байгууллага орлогод аваагүй байна. Уг шийдвэрийн хэрэгжилт 99.6 хувьтай байна

*Хүснэгт 2 Балансаас баланст шилжүүлэх шийдвэрийн хэрэгжилт /дансны ангиллаар/
/Сая төгрөгөөр/*

№	Дансны ангилал	Балансаас баланст шилжүүлэх хөрөнгө				Орлогодоогүй хөрөнгө		Хэрэгжилт
		Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Тоо ширхэг	Үнэ	
1	Барилга байгууламж	71	2,368.0	377.8	1,990.1	1	10.5	99.6%
2	Тээврийн хэрэгсэл	39	789.9	435.4	354.5	1	10.0	98.7%
3	Тоног төхөөрөмж	790	1,165.2	629.6	535.7	-	-	100%
4	Тавилга эд хогшил	233	240.2	111.5	128.7	-	-	100%
5	Бусад үндсэн хөрөнгө	3	108.0	-	108.0	-	-	100%
	Нийт дүн	1,136	4,671.3	1,554.4	3,116.9	2	20.5	99.6%

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 46.8 сая төгрөгийн үнэ бүхий үлдэх өртөггүй 3 тээврийн хэрэгслийг сэлбэгээр ашиглахаар шийдвэрлэсэн байна.

Сэлбэгээр худалдан борлуулахаар 84.8 сая төгрөгийн үнэ бүхий үлдэх өртөггүй 34 тээврийн хэрэгслийг 33.5 сая төгрөгөөр худалдан борлуулахаар шийдвэрлэсэн. Уг сэлбэгээр худалдан борлуулах дуудлага худалдааг байгууллага дээрээ зохион байгуулан 43.0 сая төгрөгөөр худалдан борлуулж 18.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Сэлбэгээр худалдан борлуулахаар шийдвэрлэсэн шийдвэрийн хэрэгжилт 82,3 хувь байна.

Акталж устгахаар нийт 4,388.6 сая төгрөгийн үнэ бүхий 3610 хөрөнгийг шийдвэрлэсэн ба 2 нэр төрлийн 13.2 мянган төгрөгийн хөрөнгийг 2 байгууллага данснаас хасаагүй байна. Уг шийдвэрийн хэрэгжилт 99,7 хувь байна.

*Хүснэгт 3 Акталж устгах шийдвэрийн хэрэгжилт /дансны ангиллаар/
/Сая төгрөгөөр/*

№	Дансны ангилал	Акталж, устгахаар шийдвэрлэсэн				Данснаас хасаагүй хөрөнгө		Хэрэгжилт
		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Тоо ширхэг	

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

1	Барилга байгууламж	43	611.3	776.0	341.8	434.3	43	611.3	98.3%
2	Тээврийн хэрэгсэл	32	179.3	194.4	194.4	-	32	179.3	100%
3	Тоног төхөөрөмж	1549	2,496.8	3,097.0	2,030.0	1,067.0	1549	2,496.8	100%
4	Тавилга эд хогшил	1742	148.0	290.0	270.1	20.0	1742	148.0	100%
5	Бусад үндсэн хөрөнгө	244	31.2	31.2	26.9	4.3	244	31.2	100%
Нийт дүн		3610	3,466.7	4,388.6	2,863.1	1,525.5	2.0	13.2	99.7%

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Акталж данснаас хасах шийдвэр гаргасан хөрөнгөөс гадна орлогод авч бүртгэхээс өмнө иргэнд бэлэглэсэн, шүүхийн шийдвэрээр шилжүүлсэн дараах хөрөнгүүд байна. Үүнд:

- 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Зуунмод сумын “Номт” 1 дүгээр багийн “Өгөөж сүмбэр” хотхоны 7 дугаар байрны 6 тоот 47.4 м2, 2 өрөө орон сууцыг Монгол Улсын Дархан мэргэн, үндэсний сурын харваач Х.О-д /2017 онд ашиглалтад орсон байрыг Х.О нь өөрийн өмчлөлд шилжүүлэхээр хүсэлт өгч явсаар Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 123/ШШ2022/0033 дугаар тогтоолыг үндэслэж шилжүүлсэн/, “Бодь Тэгри” хотхоны 61.95 м2, 3 өрөө 702 тоот орон сууцыг Монгол Улсын начин Э.У нарт тус тус олгохоор шийдвэрлэсэн тогтоол гарч олгосон байна.
- 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Монгол Улсын заан цол хүртсэн Д.Х, Монгол Улсын харцага цол хүртсэн Э.У нарт тус бүр 3 өрөө байрыг олгохоор шийдвэрлэсэн тогтоол гаргасан байна. /Монгол Улсын харцага цол хүртсэн Э.У-д дахин байр олгоогүй байна/

Дээрх тогтоолууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5-д “Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байсан тул санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсөн.

Б.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын дагуу хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгасан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 оны хугацаанд гаргасан хөрөнгө шийдвэрлэх тогтоолын дагуу дуудлага худалдаагаар борлуулах, балансаас баланст шилжүүлэх, сэлбэг хэрэгслээр ашиглах болон худалдах, акталж устгахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 4,612.6 сая төгрөгийн өртөг бүхий 139 барилга байгууламж,
- 4,160.4 сая төгрөгийн үнэлгээтэй 245 тээврийн хэрэгсэл,
- 4,262.1 сая төгрөгийн өртөгтэй 2,619 тоног төхөөрөмж,
- 530.3 сая төгрөгийн үнэлгээтэй 1,975 ширхэг тавилга, эд хогшил,
- 139.2 сая төгрөгийн үнэлгээтэй 247 ширхэг бусад үндсэн хөрөнгө.

Эдгээр хөрөнгийн шилжилт, хөдөлгөөнийг тогтоолын дагуу данс бүртгэлд үнэн зөв бүртгэж, тайлагнасан байна.

Балансаас баланст шилжүүлэхээр нийт 4,671.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1,554.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 3,116.9 сая төгрөгийн



үлдэх өртөг бүхий 1,136 ширхэг үндсэн хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргасан байна.

Аудитын хамрах хугацаанд дээрх хөрөнгийг балансаас баланст шилжүүлснээс гадна, төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор дараах хөрөнгийн шилжилт хийгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 187 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги,

бүтцийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт орон агентлагийн нэр буюу орон тоог шинэчлэн тогтоож, уг тогтоолын дагуу орон нутагт Мал эмнэлгийн газар газар байгуулагдсан. Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 сарын 30-ны өдрийн 09 дугаар тогтоолоор 1,527.3 сая төгрөгийн үнэтэй, 599.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 81 нэр төрлийн 110 ширхэг хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын балансаас Мал эмнэлгийн газрын баланст шилжүүлсэн байна.

- Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасан байна. Уг тогтоолын 2.3 дах хэсэгт мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллаж байгаа салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг орон тоо, төсөв, ашиглаж буй компьютер техник, хэрэгслийн хамт одоо эрхэлж байгаа чиг үүрэг, мэргэжлийн чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.1-д




ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

заасан байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах гэж заасны дагуу аймгийн ИТХ-ын XIV хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолоор 1,104.1 сая төгрөгийн үнэтэй, 934.4 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 272 нэр төрлийн 326 ширхэг хөрөнгийг 11 байгууллагын баланс руу шилжүүлсэн байна.

Шилжүүлсэн хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд бүрэн тусгаж, тайлагнасан байна.

Акталж устгахаар нийт 4,388.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2,863.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 1,525.5 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий 3,610 ширхэг үндсэн хөрөнгийг шийдвэрлэсэн байна.



Энэхүү шийдвэрийн дагуу дээрх хөрөнгийг актлан данснаас хасаж, данс бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт 4 Үлдэх өртөгтэй хөрөнгө акталж устгасан байгууллагуудын жагсаалт /сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нэр төрлийн тоо	Ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Аймгийн ЗДТГ	9	39	7.5	5.8	1.7
2	Биеийн тамир спортын газар	1	1	1.0	0.6	0.4
3	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын газар	1	1	197.5	98.8	98.8
4	Музей	7	7	6.8	2.4	4.4
5	Мэргэжлийн хяналтын газар	6	6	1.9	1.1	0.8
6	Нэгдсэн эмнэлэг	4	4	24.5	19.6	4.9
7	Орон нутгийн өмчийн газар	4	4	1.7	1.3	0.4
8	Статистикийн хэлтэс	4	4	0.8	0.5	0.3

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

9	Нийтийн номын сан	2	25	5.4	3.3	2.2
10	Төв Чандмань ДЭХГ ОНӨААТҮГ	223	367	1,890.9	867.5	1,023.4
11	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	51	202	41.7	36.4	5.4
12	Цагдаагийн газар	308	528	194.2	129.3	64.8
13	Эрүүл мэндийн газар	1	3	0.4	0.2	0.1
14	Бүрэн сумын ЗДТГ	2	2	117.5	21.5	96.1
15	Баянжаргалан сумын ЗДТГ	2	2	29.3	6.7	22.7
16	Бүрэн сумын Цэцэрлэг	1	1	50.7	9.2	41.5
17	Эрдэнэ сумын ЗДТГ	4	4	81.0	29.3	51.7
18	Баян сумын цэцэрлэг	1	1	123.2	23.9	99.3
19	Боловсрол, шинжлэх ухааны газар	1	1	0.9	0.4	0.5
20	Сэргэлэн сумын ЗДТГ	1	1	8.0	1.8	6.2
Нийт дүн			1,203.0	2,784.9	1,259.4	1,525.5

БҮЛЭГ В. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаас баталсан 2020-2024 оны “Хөрөнгө шийдвэрлэх тухай” тогтоолын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

В.1. Худалдан борлуулсан хөрөнгийн үнэ төсөвт дутуу буюу 44,7 хувьтай төвлөрсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон хуралдаанаас 2020–2024 оны “Хөрөнгө шийдвэрлэх тухай” тогтоолоор нийт 2,502.7 сая төгрөгийн өртөг бүхий 3 дансны 442 ширхэг хөрөнгийг худалдан борлуулах мөн 84.8 сая төгрөгийн өртөг бүхийн 34 ширхэг тээврийн хэрэгслийг сэлбэг болгон худалдахаар шийдвэр гаргасан байна.

Хөрөнгө шийдвэрлэх тухай 2020–2024 оны тогтоолын дагуу нийт 144 ширхэг хөрөнгийг 878.2 сая төгрөгөөр худалдан борлуулсан боловч үүнээс зөвхөн 44,7 хувь буюу 393.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, үлдсэн 55,2 хувь буюу 484,7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

*Хүснэгт 5 Нийт худалдан борлуулахаар шийдвэрлэсэн хөрөнгийг дансны ангиллаар харуулбал
/Сая төгрөгөөр/*

№	Дансны ангилал	Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн				
		Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	Барилга байгууламж	8	70.9	47.3	23.5	30.9
2	Тээврийн хэрэгсэл	47	681.2	676.2	5.0	51.9
	2020 оны дүн	55	752.0	723.5	28.5	82.8
3	Барилга байгууламж	5	85.3	18.2	67.1	95.7
4	Тээврийн хэрэгсэл	23	553.5	501.0	52.5	84.6
	2021 оны дүн	28	638.9	519.2	119.6	180.3
5	Барилга байгууламж	2	46.2	5.2	41.0	20.8
6	Тээврийн хэрэгсэл	15	358.0	336.3	21.6	58.5
	2022 оны дүн	17	404.2	341.5	62.7	79.3
7	Барилга байгууламж	3	130.4	10.0	120.4	20.0
8	Тээврийн хэрэгсэл	31	797.7	784.0	13.7	147.5
	Тоног төхөөрөмж	140	-	-	-	188.4

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

	2023 оны дүн	176	928.1	794.0	134.1	355.9
9	Барилга байгууламж	7	1,135.8	11.9	1,123.8	1,563.8
10	Тээврийн хэрэгсэл	21	393.6	393.6	-	52.4
11	Тоног төхөөрөмж	140	-	-	-	188.4
	2024 оны дүн	168	1,529.4	405.5	1,123.8	1,804.5
	НИЙТ	442	4,252.5	2,783.8	1,468.7	2,502.7

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Үүнийг дансны ангиллаар задалбал: Барилга байгууламж

Аудитын хамрах хугацаанд аймгийн ИТХ-ын тогтоолоор нийт 25 барилга байгууламжийг худалдан борлуулахаар шийдвэрлэсэн бөгөөд худалдах доод үнийг 1,731.1 сая төгрөгөөр тогтоож өгсөн байна. Үүнээс 6 барилга нь түүний доорх газрын хамт үнэлэгдэн дуудлага худалдаагаар худалдан борлуулагдсан байна.

Хүснэгт 6 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн барилга байгууламжийг аудит хамрах хугацаагаар харуулбал: /Сая төгрөгөөр/

№	Он	Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн				
		Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	2020 оны дүн	8	70.9	47.3	23.5	30.9
2	2021 оны дүн	5	85.3	18.2	67.1	95.7
3	2022 оны дүн	2	46.2	41.0	5.2	20.8
4	2023 оны дүн	3	130.4	10.0	120.4	20.0
5	2024 оны дүн	7	11.9	11.9	-	1,563.8
	НИЙТ	25	344.8	128.5	216.3	1,731.1

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Худалдан борлуулахаар шийдвэрлэсэн барилга байгууламжид холбогдох журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан байна. Үүний үр дүнд 15 барилга байгууламжийг нийт 146.9 сая төгрөгөөр борлуулахаар шийдвэрлэж, үүнээс 97.1 сая төгрөгийг төсөвт бүрэн төвлөрүүлжээ. Харин үлдсэн 10 барилга байгууламж нь дуудлага худалдаанд оролцогч ирээгүй зэрэг шалтгаанаар борлуулагдаагүй байна.

Хэрэгжилт хангагдаагүй 1,580.8 сая төгрөгийн 98,6 хувь буюу 1,558.8 сая төгрөг нь аймгийн ИТХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 19 дүгээр хуралдаанаар батлагдсан "Хөрөнгө шийдвэрлэх тухай" 7 дугаар тогтоолд заасан "Төв Чандмань ДЭХГ" ОНӨААТҮГ-ын хуучин дулааны станцын барилга болон түүний доорх эзэмшлийн газрыг дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэнтэй холбоотой байна. Мөн борлуулсан барилга байгууламжийн 49.8 сая төгрөгийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 7 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн тээврийн хэрэгслийн аудит хамрах хугацаагаар харуулбал: /Сая төгрөгөөр/

№	Огноо	Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан					
		Тоо ширхэг	Худалдсан үнэ	Төсөвт төвлөрсөн дүн	Зөрүү тоо хэмжээ	Хэрэгжээгүй мөнгөн дүн	Төсөвт төвлөрөөгүй мөнгөн дүн
1	2020 оны дүн	7	26.5	22.8	1	7.0	3.7
2	2021 оны дүн	3	55.2	13.5	2	-	41.7
3	2022 оны дүн	1	24.9	22.5	1	13.0	2.4
4	2023 оны дүн	3	34.8	32.8	-	-	2.0
5	2024 оны дүн	1	5.5	5.5	6	1,558.8	-
	НИЙТ	15	146.9	97.1	10	1,580.8	49.8

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Тээврийн хэрэгсэл: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 онуудад гарсан хөрөнгө шийдвэрлэх тогтоолоор нийт 2,783.9 сая төгрөгийн өртөгтэй 137 ширхэг тээврийн хэрэгслийг худалдан борлуулах доод үнийг 394.8 сая төгрөгөөр тогтоож өгсөн байна.

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

*Хүснэгт 8 Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн тээврийн хэрэгслийн аудит хамрах хугацаагаар харуулбал:
/Сая төгрөгөөр/*

№	Огноо	Дуудлага худалдаагаар худалдан борлуулахаар шийдвэрлэсэн хөрөнгө				
		Тоо ширхэг	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	2020 оны дүн	47	681.2	676.2	5.0	51.9
2	2021 оны дүн	23	553.5	501.0	52.5	84.6
3	2022 оны дүн	15	358.0	336.3	21.6	58.5
4	2023 оны дүн	31	797.7	784.0	13.7	147.5
5	2024 оны дүн	21	393.6	393.6	-	52.4
	НИЙТ	137	2,784.0	2,691.1	92.8	394.8

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Худалдан борлуулахаар шийдвэрлэсэн тээврийн хэрэгслүүдэд холбогдох журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулсан байна. Үүний үр дүнд 103 ширхэг тээврийн хэрэгслийг нийт 688.2 сая төгрөгөөр борлуулахаар шийдвэрлэж, үүнээс 277.3 сая төгрөгийг төсөвт бүрэн төвлөрүүлжээ. Харин үлдсэн 34 ширхэг тээврийн хэрэгслийн хувьд дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй болон дуудлага худалдаанд оролцогч ирээгүй зэрэг шалтгаанаар борлуулагдаагүй байна. Мөн худалдан борлуулсан тээврийн хэрэгслийн 410.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

*Хүснэгт 9 Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан тээврийн хэрэгслийн орлогыг төвлөрүүлсэн байдал хэрэгжилтийг аудит хамрах хугацаагаар харуулбал
/Сая төгрөгөөр/*

№	Дансны ангилал	Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан /Тээврийн хэрэгсэл/					
		Тоо ширхэг	Худалдсан үнэ	Төсөвт төвлөрсөн дүн	Зөрүү тоо хэмжээ	Хэрэгжээгүй мөнгөн дүн	Төсөвт төвлөрөөгүй мөнгөн дүн
1	2020 оны дүн	29	149.3	46.2	18	29.8	103.2
2	2021 оны дүн	18	93.9	0.6	5	43.6	93.4
3	2022 оны дүн	15	125.6	19.5	-	-	106.1
4	2023 оны дүн	26	271.2	162.8	5	7.5	108.4
5	2024 оны дүн	15	48.3	48.3	6	14.8	-
	НИЙТ	103	688.2	277.3	34	95.6	410.9

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

Сэлбэг болгон худалдахаар 34 ширхэг тээврийн хэрэгслийн худалдах доод үнийг 33.5 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс 26 ширхэг тээврийн хэрэгслийг нийт 43.1 сая төгрөгөөр борлуулсан боловч зөвхөн 18.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, үлдсэн 24.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Тоног төхөөрөмж: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит бус 7 дугаар хуралдааны 7 дугаар тогтоол, 2024 оны 9 дүгээр хуралдааны 7 дугаар тогтоолоор тус тус “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын баланст бүртгэлтэй 140 ширхэг тоног төхөөрөмжийн худалдах доод үнийг 188.4 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүний дагуу дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч оролцогч оролцоогүй шалтгаанаар хэрэгжээгүй байна.

*Хүснэгт 10 Дуудлага худалдаагаар худалдан борлуулсан хөрөнгийн төвлөрүүлсэн, болон төвлөрүүлээгүй орлогын дүнг аудит хамрах хугацаагаар харуулбал
/Сая төгрөгөөр/*

Дансны нэр	он	Тоо ширхэг	Худалдсан тоо ширхэг	Худалдсан үнэ	Төвлөрүүлсэн дүн	Төвлөрүүлээгүй дүн
Барилга	2020	8	7	26.5	22.8	3.7
	2021	5	3	55.2	13.5	41.7
	2022	2	1	24.9	22.5	2.4
	2023	3	3	34.8	32.8	2.0

**ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020-2024 ОНЫ ХӨРӨНГӨ ШИЙДВЭРЛЭХ
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

	2024	7	1	5.5	5.5	-
Барилга дүн		25	15	146.9	97.1	49.8
Тээврийн хэрэгсэл	2020	47	29	149.3	46.2	103.1
	2021	23	18	93.9	0.6	93.4
	2022	15	15	125.6	19.5	106.1
	2023	31	26	271.2	162.8	108.4
	2024	21	15	48.3	48.3	-
Тээврийн хэрэгсэл дүн		139	103	688.2	277.3	410.9
Сэлбэг	2020	7	4	0.6	0.6	-
	2021	5	5	1.1	0.9	0.3
	2022	2	2	1.4	1.3	0.1
	2023	9	5	21.2	4.9	16.3
	2024	11	10	18.8	11.2	7.6
Сэлбэг дүн		34	26	43.1	18.8	24.3
НИЙТ		196	144	878.2	393.2	484.9

Эх сурвалж: /Аймгийн ИТХ-ын 2020-2024 оны тогтоолууд/

В.2. Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо болон Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газрууд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитын хамрах хугацаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас баталсан “Хөрөнгө шийдвэрлэх тухай” тогтоолын хэрэгжилтэд Хурлын хороодоос тавих хяналт хангалтгүй байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 дүгээр захирамжаар аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, албан тушаалын болон, худалдан борлуулахаар аймгийн ИТХ-ын шийдвэртэй орон сууцуудын өмчлөл, ашиглалт, борлуулалтын хөрөнгийн эргэн төвлөрүүлэлттэй холбоотой асуудлыг шалгахад 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг, 2022 оны 12 дугаар 22-ны өдрийн 40 дугаар захирамжаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй тус тус байгуулсан боловч хяналт шалгалт хийгдээгүй үр дүнг тооцож ажиллаагүй байна. Хяналт тавьж үр дүнг тооцож ажиллаагүйгээс нийт 484.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил байна.



Дуудлага худалдааг зохион байгуулж холбогдох хөрөнгүүдийг худалдан борлуулсан боловч дуудлага худалдааны орлогыг төсөвт төвлөрүүлээгүй асуудлыг ОНӨГ-ын дотоод хяналтын баг илрүүлж хуулийн байгууллагад шилжүүлэн шалгагдаж байна.

Аудитаар нийт 3,313.8 сая төгрөгийн 6 зөрчил илэрснээс 1,426.7 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгөх, 1,887.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгөхөөр тус тус шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

- Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 онд гаргасан хөрөнгө шийдвэрлэх тухай 25 тогтоолыг хэрэгжүүлэхээр 15 удаагийн дуудлага худалдаа, балансаас баланст шилжүүлэн бүртгэх, акталж данснаас хасаж нягтлан бодох бүртгэлд тусгах зэрэг үйл ажиллагаанууд хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилт нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна. Энэ нь “Төв Чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ-ын хуучин дулааны станцын барилга, тоног төхөөрөмжийг дуудлага худалдаагаар худалдахаар 2023, 2024 онд 2 удаа тогтоол гарсан боловч оролцогч оролцоогүйн улмаас дуудлага худалдаа амжилтгүй болж, хөрөнгө шийдвэрлэх тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа гол шалтгаан болсон байна.
- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо болон Санхүү төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүйгээс нийт 484.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөх нь:

- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргах.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлж хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах.

Аймгийн Засаг дарга (Л.Төмөрчөдөр)-д зөвлөх нь:

- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж, хяналт тавьж ажиллах.

Орон нутгийн өмчийн газрын дарга (Д.Батжаргал)-д, Санхүү Төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д нарт зөвлөх нь:

- Дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой анхан шатны баримтыг бүрэн хөтөлж, баримтжуулах.
- Хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж дуудлага худалдааны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж төсвийг хохиролгүй болгох.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**
Номт 1 дүгээр баг, Зууимод сум, Төв аймаг, 41111
Утас: 70274066, Факс: (976) 70272354
Цахим шуудан: tovith.mn@gmail.com
Цахим хаяг: www.tov.khural.mn

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2025.07.31 № 236
танай _____ -ны № _____ -г

Аудитын тайлантай танилцсан тухай

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 оны хөрөнгө шийдвэрлэх тухай тогтоолуудын хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайланд аймгийн ИТХ-аас баталсан “Хөрөнгө шийдвэрлэх тухай” тогтоолын хэрэгжилтэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо хяналт тавьж ажиллаагүй талаар тусгагдсан байна.

Хурлын хороо дээрх хугацаанд тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй нь үндэслэлтэй бөгөөд энэхүү гүйцэтгэлийн аудитын тайланг Хурлын төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар аймгийн ИТХ-ын даргаар албан бичиг хүргүүлж, хяналт тавьж ажиллахаа илэрхийлж байна.


НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ,
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭӨНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА А.БАТЦЭЦЭГ

125090188

Дарга Ц.Хишигжаргал

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**ТӨВ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум

Утас: 70272483, Цахим шуудан: tuvumch@gmail.com

2025.08.01 № 01/165
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 оны хөрөнгө шийдвэрлэх тогтоолын хэрэгжилт сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал, тайлбар байхгүй болно.

ДАРГА

Д.БАТЖАРГАЛ



412503050